

Халх голын дайнд оролцсон халимаг дайчид (О калмыцких военных — участниках событий на Халхин-Голе)

*Наранжаргал Норовсамбуу*¹

¹Центр по изучению языка, истории и культуры ойратов «Тод номын гэрэл»
(8, район Сухбаатар, ул. Бага тойруу, 210646 Улан-Батор, Монголия)
научный сотрудник

© КалмНЦ РАН, 2020

© Норовсамбуу Наранжаргал, 2020

Аннотация. Автор на основе архивных материалов, публикаций в СМИ, воспоминаний участников событий и исследований раскрывает страницы истории военного сотрудничества монголов и калмыков, их участие в сражениях на Халхин-Голе в 1939 г. Монгольско-калмыцкое сотрудничество, в котором наблюдался всплеск в начале 1920-х гг., к 1925 г. было свернуто, большинство калмыцких военных специалистов покинуло Монголию. Военные события, развернувшиеся летом 1939 г. на реке Халхин-Гол, привели к тому, что в Монголию вновь были направлены калмыцкие военные специалисты и младший комсостав, принявшие участие в боевых сражениях. Среди участников этих событий М. Т. Бимбаев, Л. С. Эрендженев, М. Калыков и многие другие, удостоенные боевых наград. Многие из них в последующем оказались в депортации, а после возвращения из Сибири трудились в Калмыкии. Ярким свидетельством гордости калмыков о своих соотечественниках, сражавшихся за независимость Монголии, является улица Халхин-Гола в г. Элисте, названная в честь славной победы.

Ключевые слова: Халхин-Гол, Монголия, военные советники, калмыки, воспоминания, депортация

Благодарность. Материалы статьи апробированы на Международной научной онлайн-конференции «Монголоведение в начале XXI в.: современное состояние и перспективы развития – II», проведенной при финансовой поддержке РФФИ (проект № 20-09-22004) и частичной поддержке гранта Правительства РФ (№ 075-15-2019-1879).

Для цитирования: Наранжаргал Н. Халх голын дайнд оролцсон халимаг дайчид // Desertum Magnum: studia historica. 2020. № 1. С. 96–103. DOI: 10.22162/2712-8431-2020-1-1-96-103

UDC 355.48

DOI: 10.22162/2712-8431-2020-9-1-96-103

Kalmyk Militaries — Participants of Khalkhin-Gol Battle

*Naranzhargal Norovsambuu*¹

¹ “Tod nomin gerel” Center for the Study of the Oirat Language, History and Culture (8, Sukhbaatar district, st. Baga Toyruu, Ulan Bator 210646, Mongolia) Research Associate

© KalmSC, 2020

© Naranzhargal Norovsambuu, 2020

Abstract. The author describes the history of the military collaboration of the Kalmyks and Mongols and their participation in the battles of Khalkhin-Gol in 1939 based on the archive materials, mass media publications, memoirs of the participants and researchers. Mongol-Kalmyk collaboration hiked in 1920s and was wound down by 1925 and most of the Kalmyk military experts left Mongolia. In the summer of 1939 the military events at the river Khalkhin-Gol caused sending the Kalmyk military experts and junior commanders back to Mongolia where they took part in the battles. Among the participants of that event were M. T. Bimbaev, L. S.Erendzhenov, M. Kalykov and many others who were honored with military awards. Many of them were deported later and after coming back from Siberia worked in Kalmykia. The clear illustration of Kalmyks being proud of their compatriots who fought for the independence of Mongolia is naming one of the streets in Elista Khalkhin-Gol – in honor of the great victory.

Keywords: Khalkin-Gol, Mongolia, military advisors, memoirs, deportation

Acknowledgement. The article was presented at the international scientific online conference “Mongolian Studies at the beginning of the 21st century: Current State and Development Prospects – II”, held with the financial support of RFBR (project № 20-09-22004) and partial support of the Russian Government Grant (№ 075-15-2019-1879).

For citation: Naranzhargal Norovsambuu. Kalmyk Militaries — Participants of Khalkhin-Gol Battle. In: Desertum Magnum: studia historica. 2020. № 1. Pp. 96–103. DOI: 10.22162/2712-8431-2020-9-1-96-103

1920-иод оны эхээр идэвхтэй хөгжиж эхэлсэн Монгол-Халимагийн харилцаа 1924 он гэхэд эрс суларчээ. 1921 оны хувьсгалын гол дайн байлдаанд халимаг дайчид оролцож, дараагаар Халимагаас олон тооны сургагч ирж Монголын шинэ бүтээн байгуулалтад оролцсон, Халимагийн нутагт болсон ган гачигийн улмаас халимагууд өлсгөлөнд нэрвэгдэхэд Монголын ард түмэн, Засгийн газраас тусламж үзүүлсэн гээд харилцаа маш идэвхтэй өрнөж байсан юм. Монгол улсын Засгийн газраас халимагуудыг бүгдийг нь болон хэсэгчилсэн байдлаар Монгол улсад нүүлгэн ирүүлэх тогтоол гарах хэмжээний ихээхэн амжилт олж байсан харилцаа ЗОУ-ын бодлоготой үл нийцэх болсноор бүх талын харилцаа эрс суларч Монголд байсан халимаг сургагч нарын ахлагчийг нь баривчлан, сургагч нарыг цэргээс халан нутагт нь буцааснаар нэг үе дуусчээ.

1930-аад оны дунд үеэс Монголын дорнод хилийн байдал тогтворгүй болсноор ЗХУ-ын зүгээс цэргийн талаар Монголтой харилцах харилцаагаа идэвхжүүлж, 1936 онд хэн нэгэнд нь гуравдагч этгээд халдан довтолбол харилцан туслалцах албан ёсны гэрээг байгуулж [Монгол улсын түүх 2004: 216], Монголд ажиллах цэргийн мэргэжилтэн сургагч нарынхаа тоог нэмэгдүүлсэн байна. Ингэхдээ урьд Монголд ажиллаж байсан туршлагатай хүмүүс, монголчуудтай шууд харилцаж чаддаг халимагуудыг дахин ашиглах болов. Эдгээр халимагуудын нэг болох М. Т. Бимбаевыг 1936 онд дахин Монголд ирүүлсэн бөгөөд тэрээр Халх голын дайнд Монголын морин цэргийн 6-р морьт дивизийн штабын зөвлөхөөр оролцоод дайны дараа 1939 онд нутаг буцжээ [Бимбаев 1983: 62–71].

М. Т. Бимбаев нь энэ үед Монголд ажиллаж байхдаа Монголын нисэх хүчний үндэс суурь болсон Буянт-Ухаагийн нисэх онгоцны буудал болон говийн аймгуудын нисэх онгоцны буудал байгуулах судалгааг гаргасан ба тэрхүү судалгаан дээр нь үндэслэн нисэх онгоцны буудал байгуулсан гэх аман мэдээ байдаг.

1939 онд дайн дэгдэх нь нэгэнт тодорхой болсноор Монголын армийг бэхжүүлэх чадваржуулах үүднээс тэдэнтэй ажиллахад хэл ус, сэтгэлгээний талаар арай илүү дөхөм байж болох Зөвлөлтийн армид алба хааж байсан халимаг бага дарга нарыг Монгол руу томилон явуулах болов.

1939 онд Халх голын дайнд оролцсон ахмад дайчин С. Ш. Улакчинов энэ тухай «<...> 1939.1.2 нд Белорусын цэргийн тойргийн Самарын 7-р морьт дивизийн Астарханы 37-р морьт хороонд алба хааж байхад нь халимаг угсаатай бага дарга нарыг яаралтай цуглуулан өөр газар ажиллуулах тухай тушаал ирснээр С. Б. Бюрюев, Д. Я. Голдунов,

Б. С. Мухаев, М. С. Омадыков, Б. Л. Тюрбеев, М. Улюмджиев, Б. Шамаев, С. Ш. Улакчинов нарыг В. Ф. Романовд захируулан Москва руу явуулсан. Москвад очоод Ставрополь хотын Астарханы морьт хорооноос ирсэн Ц. А. Доржиев, С. Корсиков, Д. Молотков, Т. С. Онкаев, О. Уланов, И. Эрдниев, О. Амбушев, Андрушкаев нарын бага дарга нартай нийлэн 17 хүн 1939 оны 7 сард Монголд ирж, Монголын Хувьсгалт Цэргийн Армид мэргэжилтнээр ажиллах болсон» хэмээн дурссан байдаг [Улакчинов 1981: 56–80]. Тэрээр Монголын цэргийн анги болон Ерөнхий штаб, Армийн улс төрийн Ерөнхий хороонд 5 жил ажиллаад 1944 оны 5 сард нутаг буцсан. Зөвлөлтөд буцаж ирснийхээ дараа 1949 он хүртэл тэрээр Москвад сурч байсан монголын цэргийнхэнд багшилсан байна. Москва дахь түүний анхны сонсогч нар нь Дашпунцагийн Самбуудорж, Дашжавын Намсрай, Дарийн Чулуун, Дэжидийн Юндэн, Сономын Батсүх, Чимидийн Ишцэнд, Шагдарын Дугарсүрэн, Шаравын Мягмар, Шадавын Шархүү, Дугарсүрэн зэрэг 10 хүн байжээ.

С. Ш. Улакчинов оролцсон уг бүлэг 1939 оны 8 сарын 3нд Улаанбаатарт ирсэн ба 1939 оны 11 сараас М. С. Омандыковыг Говийн 34-р морьт хорооны 10-р морин дивизийн орчуулагчаар 1940 оны 5 сар хүртэл ажиллуулаад 34-р морин хорооны 8-р морин дивиз руу шилжүүлжээ. Түүнтэй хамт тус хороонд нь Халимагаас хамт ирсэн В. Ф. Романов, И. Л. Эрдниев нар ажиллаж байсан аж. Тэрээр 1940 онд амралтаараа Улаанбаатарт ирэхэд халимаг сургагч олон байсан тухай дурссан байдаг. 1944 оны 1 сараас түүнийг МАХА-ын 5-р морин дивизэд шилжүүлсэн. Тус хороонд түүнээс гадна халимаг Д. Я. Годунов, А. С. Молотов, Б. Тюрбеев нар орчуулагчаар ажиллаж байжээ [Омадыков 1981: 80–100]. Эдгээрээс гадна тухайн үед Монголд ажиллаж байсан Николай Лиджиев нь Халх голын дайны үед тагнуулын группэд болон Х. Чойбалсангийн хувийн хамгаалалтад ажиллаж байв. Түүнийг тагнуулын үүргээ маш сайн биелүүлсэн тул Монгол улсын «Хүндэт чекист» цол олгосон байна. Мөн Убуша Андриюшкеев Монгол улсын Дотоодыг хамгаалах газрын улсыг аюулаас хамгаалах төв газрын захиргаанд орчуулагч, нарийн бичгээр, Никита Миронович Бадиев Зөвлөлтийн элчин сайдын газар болон тагнуулд ажиллаж байв [Годаев 2004].

Эдгээр бага дарга нарыг Белорусын цэргийн тойргийн Самарын морин цэргийн дивизийн Астархан дахь морин цэргийн 7-р хороо болон Ставрополь хотод байсан Хойд Кавказын цэргийн тойргийн Халимагийн морин цэргийн хорооноос авчирсан байна. Эдгээр бага дарга нар Монголын дотоодыг хамгаалах газар, сөрөг тагнуулд цэргийн сургагч, орчуулагч зэрэг ажлуудыг хийж байсан.



*Зураг №1. 1939 онд Халхын голын дайны үед Халимагаас Монгол ардын
армид ажиллаж байсан халимаг сургагч нар*

Нэгдүгээр эгнээний баруун гар талаас:

1. Эрэндженов Лиджи Санджиевич. 1918 онд төрсөн. Монголын «Алтан гадас» одонгоор шагнагдсан бөгөөд Сибирийн цөллөгний дараа Ики бухас тосгонд 1962–1969 онуудад «Красносельский» хамтралын даргаар ажилласан. 1973 онд нас барсан.
2. Нэр нь тодорхойгүй

Хоёр дугаар эгнээнд сууж байгаа, баруун гар талаас:

1. Буздаев Мутул
2. Маштаков Степан
3. Андрушкиев Убуш
4. Мулаев Эрдни Ностаевич. 1911 онд төрсөн. Сибирийн цөллөгний дараа Сарпинск районы Садовое нэгдэлд ажиллаж байсан. 1999 онд нас барсан.
5. Табунов Наран.

Гуравдугаар эгнээнд, баруун гар талаас:

1. Дорджиев Лиджи
2. Манджиев Бамба Менкцеренович. 1915 онд төрсөн. Сибирийн цөллөгний дараа «Красносельский» хамтралд ажиллаж байгаад 1964 онд нас барсан. Бага дөрвөдийн Унгн Тёрячи тосгоны хүн.

3. Нэр нь тодорхойгүй
4. Болданов Дорджи
5. Назаров Санджи Кондратьевич. 1912 онд төрсөн. Халимагийн хууль сахиулах газарт ажиллаж байгаад 1963 онд нас барсан.
6. Нэр нь тодорхойгүй
7. Босхомджиев Бова Довукаевич. 1913 онд төрсөн. Сибирийн цөллөгийн дараа Бага дөрвөдөд нягтлан бодогч хийж байгаад 1973 онд нас барсан. Бага дөрвөдийн Хончнур тосгоны хүн.
8. Яванов Эрдни

Дөрөвдүгээр эгнээнд зогсож байгаа, баруун гар талаас:

1. Балдуев Никита
2. К. Ностаев
3. Лиджиев Николай
4. Тюмидов Бадма-Церен
5. Телеев Анджа
6. Манджиев Гудун Манджиевич. 1913 онд төрсөн. 1944 онд Монголоос шууд Новосибирск-д цөллөгдөөд 1950 онд нас барсан. Бага дөрвөдийн Хончнур тосгоны хүн.
7. Анджаев Манджи Цебекович. 1910 онд төрсөн. 1983 онд нас барсан. Сарпин районы Шин тосгоны хүн. Халх голын дайн эхлэхээс өмнө Монголд ирсэн.
8. Джуринов Нимгир
9. Манджиев Мутул [Эрдниев 2012].

Халх голын дайнд оролцсон Халимаг сургагч нарын бүртгэлийг 1976 онд Халимагийн сайд нарын зөвлөлөөс гаргасан. Уг бүртгэлээр Халхын голын дайнд оролцсон ахмад дайчид Сарпин районд 9, Юстник районд 5, Лагань районд 11, Яшалта районд 2, Бага дөрвөдөд 1, Яшкуль районд 7, Приозерн районд 4, Целинн районд 8, Прютенск районд 1, Ики бурул районд 1 нийт 49 хүн амьд сэрүүн байжээ [НА РК. Р-309. Оп. 1].

Халхын гол дайнд оролцоод шагнагдсан халимаг дайчид олон бий.

Халимагийн Бага чонос тосгоны Мутул Калыков Халх голын дайнд БТ маркын танкны механик жолоочоор оролцон тулалдсан бөгөөд тэрээр дэлхийн II дайны түүхэнд 2 удаа танкаар танк мөргөн устгасан хүн юм. Энэхүү гавьяаг нь үнэлэн «Алтан гадас» одонгоос гадна армийн командлагчийн шийдвэрээр «Байлдааны гавьяаны улаан тугийн одон»-гоор шагнагджээ [Илишкин 1995]. Түүнээс гадна Манжиев Бова Бухаев [НА РК. Р-309. Оп. 1], Т. Б. Митруев, М. Манджиев, Л. С. Эрендженев, Бова Гаряев, Очир Петькиев нарыг «Улаан тугийн одон»-гоор, Мутул Калыков, Лиджи Санджиевич Эрендженев, Н. Ш. Леджиев, Манжи Анжаев, Т. Б. Митруев, М. Манжиев, Л. Эрендженев нарыг «Алтан гадас

одон»-гоор шагнасан байна. Мөн М. С. Омадыковыг Халх голын ялалтын 30 жилийн ойн медалиар шагнажээ [Омадыков 1981: 80–100].



Халх голын дайнд оролцсон ахмад дайчид
Мутул Калыко



Мацак Бимбаев

Угсаа гарал нэгтэй монгол ах дүү нарынхаа тусгаар тогтнол, бүрэн бүтэн байдлын төлөө тулалдаж явсан эдгээр халимаг дайчдаас Оргакин аймгийн уугуул Бакаев Доди (Дорж) Хомонович (Халимович) 1939 оны 4-р сарын 26-ны өдрийн тулалдаанд амь үрэгдсэнийг цэргийн ёсоор оршуулсан байна.

Халимагууд энэхүү Монголын тусгаар тогтнолын төлөө тулалдсан халимаг дайчдаа дурсан эх орноо харийн түрэмгийлэгчдээс хамгаалан тэмцсэн Монголчуудын их тэмцэл — Халх голын дайны агуу ялалтаар бахархан Элиста хотын нэгэн гудамжийг «Халхын гол» хэмээн нэрлэсэн байдаг.

Дүгнэлт

Монголын армид сургагчаар ажиллаж байсан халимаг сургагч нарыг 1925 онд Монголоос гаргаснаар Монгол-Халимагийн харилцаа суларч цэргийн хэргээр цөөн тооны хүмүүс Монголд ажиллаж үлджээ. 1939 оны Халх голын дайнтай холбоотойгоор Улаан армид алба хааж байсан халимаг бага дарга нарыг Монгол руу томилон явуулах болсноор тодорхой тооны халимаг бага дарга, сургагч нар дахин Монголд ирж, Халх голын дайнд оролцон Монголын цэргийн анги болон улс төрийн газруудад

ажиллах болжээ. Халх голын дайны дараа дээрх халимаг сургагч бага дарга нарын ихэнхийг нутаг буцаасан бөгөөд цөөн тооны бага дарга нарыг тухайн үеийн нөхцөл байдал, арми улс төрийн үйл ажиллагааны боловсон хүчний шаардлага зэргийг харгалзан үзэж Монголд үлдээн ажиллуулсан байна. Гэвч 1943 онд халимагуудыг цөллөгт явуулахтай холбогдуулан Монгол нутгаас буцаан татаж цөллөгөнд илгээжээ. 1945 оны чөлөөлөх дайнд Монголд ажиллаж байсан цөөн тооны халимаг цэргийн мэргэжилтэн болон Улаан армийн эгнээнд цөллөгөнд яваагүй байсан халимаг цэргүүд оролцжээ.

Халимагуудыг Сибирьд цөлсөн асуудлаас болоод тухайн үед өрнөж байсан Монгол-Халимагийн харилцаа тасарчээ. Тухайн үед Монгол улс нь ЗХУ-аас олон талын тусламж дэмжлэг авч байсан учраас ЗХУ-ын бодлогыг сөрөн халимагуудыг өмгөөлөн хамгаалах, харилцах боломжгүй байлаа.

Ном зүй

- Бимбаев 1983 — *Бимбаев М. Т.* Судьба моя военная. (воспоминания о друзьях-однополчанах). Элиста: Калм. кн. изд-во, 1983. 156 с.
- Годаев 2004 — *Годаев П.* Помнит Монголия, помнит Россия... // Элистинская панорама. 2004. 6 мая.
- Илишкин 1995 — *Илишкин Н.* Незабвенные наши фронтовики. Элиста: Джангар, 1995. 160 с.
- Монгол улсын түүх 2004 — Монгол улсын түүх. V боть / ред. Ж. Болдбаатар, М. Санждорж, Б. Ширэндэв. Улан-Баатор, 2004.
- НА РК — Национальный архив Республики Калмыкия.
- Омадыков 1981 — *Омадыков М. С.* Шесть лет в Монгольской народной армии // В бою — в одном экипаже, в труде — в одной бригаде: сб. / сост. Ю. О. Оглаев. Элиста: Калм. кн. изд-во, 1981. С. 80–100.
- Улакчинов 1981 — *Улакчинов С. Ш.* Молодые крылья Монголии // В бою — в одном экипаже, в труде — в одной бригаде: сб. / сост. Ю. О. Оглаев. Элиста: Калм. кн. изд-во, 1981. С. 56–80.
- Эрдниев 2012 — *Эрдниев Е.* Верные интернациональному долгу // Степная новь — Шинрсн тег. 2012. 2 июня. С. 3.